

ОТГОНТЭНГЭР ИХ СУРГУУЛИЙН МАГИСТРЫН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД БАРИМТЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дээд боловсролын тухай хууль, Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2014 оны А/370 тоот тушаалаар баталсан “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, Отгонтэнгэр их сургуулийн /цаашид ОТИС гэх/ дүрмийг үндэслэн магистрын сургалтыг ОТИС-д зохион байгуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Тус сургуулийн магистрын сургалтын агуулга нь бакалаврын зэрэгтэй мэргэжилтнийг элсүүлэн шинжлэх ухааны тодорхой чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалтад хамруулж эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх, хүн бие дааж өөрийгөө хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал, ёс зүйг эзэмшин, мэргэшсэн мэргэжилтэн бэлтгэхэд чиглэнэ.

1.3. Магистрын судалгааны ажил нь тухайн салбарын удирдлага зохион байгуулалтад тулгамдаж буй асуудлыг сонгож шинжлэх ухааны арга зүйг ашиглан баримт өгөгдөл цуглуулах, боловсруулах, шинжилгээ хийх ур чадвар эзэмшсэн болохоо нотлон харуулсан судалгааны бүтээл байна.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт

2.1. Магистрын сургалтыг ОТИС-ийн сургалтын нэгдсэн алба эрхлэн явуулна. Сургалтын нэгдсэн алба нь ОТИС-ийн дүрмийн дагуу томилогдсон Сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлын удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг сургуулийн үндсэн нэгж болно.

2.2. Сургалтын нэгдсэн алба нь дарга, бүтцийн сургууль хариуцсан менежерүүдээс бүрдэнэ. Эрдэм шинжилгээ, судалгааны төв нь суралцагчдад судалгааны арга зүйн зөвлөгөө өгч, их семинарыг зохион байгуулж, эрдэм шинжилгээний ажлын мэдээллийн сан бүрдүүлэх, судалгааны бүтээлээр үйлчлэх ажлыг хариуцна.

2.3. Сургалтын нэгдсэн алба нь хэрэгжүүлж байгаа магистрын хөтөлбөр тус бүрээр түүнийг боловсруулах, шинэчлэх, хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн болон чанарын удирдлагаар хангаж, тухай бүр үнэлгээ хийх үүрэг бүхий хөтөлбөрийн дэд хороо ажиллуулна.

2.4. Сургалтын нэгдсэн алба нь ОТИС-ийн эрдмийн зөвлөл, бүтцийн сургууль, Эрдэм шинжилгээ судалгааны төв, магистрын хөтөлбөрийн дэд хороод болон бусад сургуулийн магистрын хөтөлбөр хэрэгжүүлэх, эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөлүүдтэй нягт хамтран ажиллаж сургалт, судалгааны ажлын чанарыг сайжруулах, цаашид хөгжүүлэх талаар арга хэмжээ авч ажиллана.

2.5. Сургалтын нэгдсэн алба нь магистрын зэргийн сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах, сургалт, судалгаа, профессор, суралцагч болон санхүүгийн үйл ажиллагаанд чанарын хяналт тавих, магистрын зэрэг хамгаалах зөвлөл байгуулах ажлыг зохион байгуулна.

2.6. Сургалтын нэгдсэн албаны үйл ажиллагааны зардал нь ОТИС-ийн төвлөрсөн төсөвт жил бүр тусгагдана. Төсвийн зарцуулалтын асуудлыг ОТИС-ийн захирлын тушаалаар зохицуулна.

2.7. Сургалтын нэгдсэн алба нь дараах үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.7.1. ОТИС-ийн стратеги төлөвлөгөө болон ОТИС-ийн Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг хөгжүүлэх 2018-2022 оны хөтөлбөртэй уялдуулан энэхүү журамд заасны дагуу магистрын сургалтыг зохион байгуулж, магистрантын суралцах орчин, судалгаа хийх нөхцөлийг бүрдүүлнэ.

2.7.2. магистрын сургалтад суралцагчийн оролцоог дэмжсэн, хөтөлбөрт суурилсан, идэвхтэй арга хэлбэрээр болон цахимаар зохион байгуулж болно.

2.7.3. магистрын судалгааны ажил нь зохиогчийн эрхийн зөрчилтэй эсэхийг шалгах зорилгоор бүтээлийн хуулбарлалт илрүүлэх /plagiarism detector/ систем бүрдүүлж, журмаар зохицуулна.

2.7.4. сургалтын үйл ажиллагааны хүрээнд магистрын сургалтын хөтөлбөр шинээр нээх, хаах, оюутан элсүүлэх, кредит цагийн биелэлт, чанарт хяналт тавих, оюутан төгсгөх, туслах /дагалдан/ багшаар ажиллуулах /бакалаврын сургалтад оролцуулж цалин урамшуулал олгох/ болон оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх;

2.7.5. судалгааны үйл ажиллагааны хүрээнд магистрантын эрдэм шинжилгээний ажлын чанар, үр дүнг сайжруулах, судалгааны туслахаар ажиллуулах /судалгааны сэдэвт ажил, төсөлд оролцуулж цалин урамшуулал олгох/ хөтөлбөр хэрэгжүүлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, хэвлэн нийтлэх бодлогыг зохион байгуулж хэрэгжүүлэх;

2.7.6. хөтөлбөрийн дагуу сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны багц цагийг чанартай биелүүлэх, судалгааны ажилд тасралтгүй оролцох, судалгааны ажлын үр дүнгээ хэлэлцүүлж, хэвлэн нийтлүүлэх, сургалт, судалгааны туслах ажилтны хөтөлбөрт хамрагдах зэрэгт магистрантын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах;

2.7.7. сургалт, судалгааны зардал, цагийн тооцоо, төлбөр, тэтгэлгийн тооцоо, хуваарилалт, зарцуулалт болон оюутны судалгааг дэмжих санхүүжилт, тэтгэлгийн сан бий болгох санхүү, эдийн засгийн үйл ажиллагааг санхүүгийн албатай хамтран зохион байгуулах.

Гурав: Магистрын хөтөлбөрт тавигдах шаардлага

3.1. Багшлах бүрэлдэхүүн

3.1.1. ОТИС нь магистрын зэргийн сургалтад хичээл заадаг багш нарт тухайн түвшний сургалтын онцлог, хөдөлмөр зарцуулалт болон тэдний мэргэжлийн ур чадварт дүйцсэн цалин хөлс олгоно.

3.1.2. магистрын сургалтад хичээл заах профессор багш нь тухайн чиглэлээр докторын зэрэгтэй байна.

3.1.3. магистрантурын сургалтад гадаад хэлний хичээл заах багш магистрын зэрэгтэй байж болох ба тухайн хэлний чиглэлээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн /TOEFL, IELTS, TESOL/ шалгалтын хангалттай оноо авсан байна.

3.1.4. магистрын сургалтад хичээл заадаг багш судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг байна. Багш нарт судалгаа шинжилгээний ажил эрхлэх боломж, нөхцөлийг холбогдох дүрэм журамд тусган бүрдүүлнэ

3.1.5. магистрын судалгааны ажлын удирдагч багш нь БСШУ-ны сайдын 2014 оны А/370 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.8.2 болон 2.8.3-д заасан шалгуурыг хангасан байна.

3.1.6. магистрантын элссэн улиралд багтаан мэргэжлийн тэнхим, оюутны саналд тулгуурласан бүтцийн сургууль суралцагч нэг бүрээр эрдэм шинжилгээний ажлын сэдвийн хүрээ, чиглэл, удирдагчийг томилох саналыг боловсруулж захирлын тушаалаар баталгаажуулна.

3.1.7. ОТИС-ийн зөвлөх профессор болон магистрын сургалтад идэвхтэйоролцдог, өөр байгууллагад судалгаа, эрдэм шинжилгээний ажил эрхэлдэг, докторын зэрэгтэй хүн магистрын сургалтад хичээл зааж, удирдагчаар ажиллаж болно.

3.1.8. удирдагч нь дараах үүрэгтэй байна. Үүнд:

3.1.8.1. магистрын судалгааны ажлын бүтэц, агуулгын багтаамж, арга зүйг тодорхойлоход зөвлөмж өгөх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах,

3.1.8.2. магистрын судалгааны ажлын төлөвлөгөөний биелэлтийг хянаж, туршилт судалгаа хийх, задлан шинжлэх, туршилтын дүнг боловсруулахад арга зүйн туслалцаа үзүүлэх, өгүүлэл бичих, илтгэл тавих зэрэг эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг удирдан чиглүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын багц цаг тооцох дүгнэлт гаргах

3.1.8.3. судалгааны ажил хийх болон бичих явцад тодорхой хуваариар мэргэжлийн зөвлөгөө өгч, хяналт тавих, судалгааны ажлын агуулгыг хэсэг бүрээр болон бүхэлд нь дүгнэх,

3.1.8.4. удирдсан магистрын судалгааны ажлыг хамгаалалтад оруулах зөвшөөрөл өгөх,

3.1.8.5. эрдэм шинжилгээний болон судалгааны семинар зохион байгуулах саналыг хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжид гаргаж магистрантад уг семинарт судалгааны ажлынхаа үр дүнг илтгэн хэлэлцүүлж байх нөхцөлийг бүрдүүлэх,

3.1.8.6. профессорын хэлэлцүүлэг, урьдчилсан хамгаалалт, төлөвлөгөөт хэлэлцүүлэгт удирдагчийн хувьд оролцох, уг зөвлөлөөс гаргасан дүгнэлттэй танилцах

3.1.8.7. судалгааны ажлын үр дүн шинжлэх ухааны үнэн зөв байдлыг хангасан эсэх, хууль зүйн хүрээнд хийгдсэн талаар хариуцлага хүлээж, тодорхойлолт гаргах

3.1.9. магистрын судалгааны ажлын сэдэв нь шинжлэх ухааны 2-3 салбарт хамаарахаар бол 2 удирдагч томилж болно.

3.1.10. тухайн чиглэлээр докторын зэрэг хамгаалсан, өндөр ур чадвартай профессорыг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж зөвлөх болон зочин профессороор урьж ажиллуулж болох бөгөөд энэ тохиолдолд албан ёсны гэрээ байгуулан ажиллуулна.

3.1.11. нэг профессорын удирдах магистрантын тоо нэг хичээлийн жилд 3-аас илүүгүй байна.

3.1.12. удирдагч багшийн ажлын үр дүнг ЗХШҮА-аас жил бүр үнэлэх ба хүлээх хариуцлага, урамшууллын асуудлыг холбогдох журамд тусгана.

3.2. Сургалтын төлөвлөгөө

3.2.1. магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөөнд хичээлийн нэр, багц цаг, хичээл хоорондын уялдаа холбоо болон хөтөлбөрт тавигдах шаардлагыг нарийвчлан тусгасан байна.

3.2.2. магистрын сургалтын ердийн хугацаа өдрөөр суралцахад 1,5-2 жил байна.

3.2.3. магистрын сургалтын төлөвлөгөө нь 30-аас доошгүй багц цагтай байна. Үүнд:

3.2.3.1. судалгааны арга зүйн хичээл 4 багц цагаас доошгүй

3.2.3.2. мэргэжлийн суурь хичээл 6 багц цагаас доошгүй

3.2.3.3. мэргэшүүлэх заавал судлах хичээл 8 багц цагаас доошгүй

3.2.3.4. мэргэшүүлэх сонгон судлах хичээл 6 багц цагаас доошгүй

3.2.3.5. магистрын ажил бичих тохиолдолд

3.2.3.5.1. удирдагч багштай ажиллах, эрдэм шинжилгээний ажил хийх 3 багц цаг

3.2.3.5.2. магистрын судалгааны ажил бичих 5 багц цаг

3.2.3.6. магистрын ажил бичихгүй тохиолдолд 10 багц цагийн нэмэлт хичээл сонгон судална.

3.2.4. салбар дундын болон мэргэжил дундын магистрын зэрэг олгох сургалтын төлөвлөгөө 32-38 багц цаг байх ба хөтөлбөрийн онцлог, хөтөлбөр хэрэгжүүлэх бүтцийн сургуулиудын санал, ОТИС-ийн эрдмийн зөвлөлийн саналыг үндэслэн ОТИС-ийн захирлын тушаалаар сургалтын төлөвлөгөөний багц цагийн хуваарилалтыг тогтооно.

3.2.5. магистрантын эрдэм шинжилгээ, судалгааны багц цагийг “Магистрант, докторантуудын эрдэм шинжилгээ, судалгааны багц цаг тооцоход баримтлах журам”-ын дагуу тооцож, баталгаажуулна.

3.2.6. магистрын сургалтын төлөвлөгөөг хамаарах хөтөлбөрийн дэд хороо боловсруулж, хэлэлцүүлэн ОТИС-ийн захирлын тушаалаар баталгаажуулна. Энэ баримт бичгийг боловсруулахдаа ОТИС-ийн сургалтын нэгдсэн албанаас гаргасан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загварыг баримтална.

3.2.7. суралцагч бүр судлах хичээлийг сонгож, ганцаарчилсан төлөвлөгөө гарган сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирлаар батлуулах ба сургалтын нэгдсэн алба хуваарь гарган баталгаажуулж, гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.

3.2.8. мэргэжлийн тэнхим сургалтын төлөвлөгөөнд заагдсан хичээл бүрээр судлах агуулгыг боловсруулж, гүйцэтгэлийг хянана.

3.2.9. өдрөөр суралцагч нэг улиралд 10-аас ихгүй багц цагийн хичээл судална. Эрдэм шинжилгээний багц цагийн гүйцэтгэлд хязгаар тогтоохгүй.

3.3. Хичээлийн хөтөлбөр

3.3.1. мэргэжлийн тэнхим сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр судлах агуулгыг багтаасан сургалтын хөтөлбөр боловсруулж, гүйцэтгэлийг хянана.

3.3.2. хичээлийн хөтөлбөр нь дараах бүтэцтэй байна. Үүнд:

3.3.2.1. хичээлийг заах багшийн нэр, эрдмийн зэрэг цол, харилцах хаяг

3.3.2.2. хичээлийн нэр, код, багц цаг
3.3.2.3. хичээлийн зорилго, зорилт
3.3.2.4. хичээлийг судалснаар хүрэх үр дүн/мэдлэг, чадвар, дадал/
3.3.2.5. хичээлийн залгамж холбоо, нэгдмэл чанар
3.3.2.6. хичээлийн товч тодорхойлолт
3.3.2.7. хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, агуулга /өдөр бүрээр төлөвлөсөн судлах зүйлийн тойм/

3.3.2.8. сургалтад ашиглах эх сурвалж, /үндсэн болон нэмэлт ном, нэг сэдэвт бүтээл, интернэт эх сурвалж гэх мэт/

3.3.2.9. гүйцэтгэх даалгавар, үнэлэх, дүгнэх арга хэлбэр, үнэлгээний хуваарь

3.3.2.10. хичээлийн хөтөлбөрийн чанарын баталгаажилт

3.3.3. магистрын хичээлийн хөтөлбөрийг тухайн хичээлийг заах профессор багш боловсруулж, хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцүүлэн батална.

3.4. Төгсөгчдийн эзэмших ур, чадвар

3.4.1. хувь хүний болон мэргэжлийн ур чадвар, дадал, төлөвшил

3.4.1.1. шинийг эрэлхийлэх, асуудал шийдвэрлэх чадвар. /Асуудлыг тодорхойлж, баримт нотолгоонд үндэслэн дүн шинжилгээ хийж, зүй тогтлыг илрүүлэх, тандан судлах, хөгжлийн хандлагыг тодорхойлох, шинэ санаа гаргах, зураглах, боломжит хувилбарыг сонгож илэрхийлэн харуулах/

3.4.1.2. шинжлэн судлах, шийдэл гаргах /Таамаглал дэвшүүлэн харьцуулсан судалгаа, анализ хийх, загварчилж баримт бичиг боловсруулах/

3.4.1.3. системтэй төлөвлөх /Мэргэжлийн сэтгэлгээгээр хандах, хоорондоо хамааралтай зүйлсийг бүхлээр нь олж харах, харилцан хамаарлыг нь ойлгох, ач холбогдлоор нь ангилан чухал санаан дээр төвлөрч шалгах, харьцуулан сонгох/

3.4.1.4. хувь хүний ур чадвар ба дадал /Шинийг санаачлах эрмэлзэлтэй, уламжлалыг дээдлэн уян хатан бүтээлч сэтгэлгээтэй байх, хувь хүний мэдлэг, ур чадвар, төлөвшлийг үнэлж ухамсарладаг, бие даан суралцах, цагийн болон нөөцийн менежментийг зөв хэрэгжүүлдэг байх/

3.4.1.5. мэргэжлийн ур чадвар, төлөвшил /Мэргэжлийн болон судлаачийн ёс зүйтэй, хариуцлагатай, чадвартай, эдийн засгийн тооцоотой байх, тасралтгүй судалгаа хийж, идэвхтэй судлаач байж шинэ мэдлэг, мэдээллийг бий болгон шинжлэх ухаанд хувь нэмрээ байнга оруулах/

3.4.2. харилцааны ур чадвар /Багаар ажиллах чадвар ба харилцаа/

3.4.2.1. аагаар ажиллах /Баг бүрдүүлэх, багийг удирдах, төслийн менежментийг хэрэгжүүлэх, манлайлах ур чадвартай байх/

3.4.2.2. харилцааны чадвар /Харилцааны стратеги, бүтцийг ойлгодог, бичгийн, электрон, мультимедиа, график дүрслэлээр болон яриа, бичгээр тайлагнах, хүнтэй харилцах үндсэн ур чадвартай байх/

3.4.2.3. гадаад хэлээр харилцах /Англи болон бусад гадаад хэлээр мэргэжлийн мэдээлэл ашиглах, илтгэх, бичих чадвартай байх/

3.4.2.4. хөтөлбөрөөр суралцсан төгсөгчийн загвар, Мэргэжлийн хичээлээр эзэмших мэдлэг, ур чадвар, чадамж, түүнийг шалгах шалгуур үзүүлэлтийг хөтөлбөрийн дэд хороо тодорхойлон батлуулж ажиллана.

3.5. Суралцагчийн үнэлгээ

3.5.1. хичээл бүрийн үнэлгээний зэрэгцээ хөтөлбөрийн үндсэн үе шат бүрийн үр дүнг дараах хэлбэрээр үнэлнэ.

3.5.1.1. явцын үнэлгээ

3.5.1.2. улирлын үнэлгээ

3.5.1.3. ур чадварын үнэлгээ

3.5.1.4. бусад үнэлгээ

3.5.2. үнэлгээ нь суралцах үйл явцыг дэмжсэн бодитой, үнэлгээний нийтлэг жишигтэй харьцуулах боломжтой байна.

3.5.3. хөтөлбөрийн үр дүн нь мэргэжлийн эрх олгохтой холбогдох тохиолдолд харгалзах мэргэжлийн шалгалтын үнэлгээний аргачлалтай нийцэхүйц байна.

3.5.4. сургалтын төлөвлөгөөнд заагдсан зарим хичээлд С буюу түүнээс дээш дүн авсан байх шаардлага тавьж болно.

3.6. Хөтөлбөрийн чанарын баталгаажуулалт

3.6.1. хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг хөтөлбөрийн хороо хагас жил тутамд үнэлж сургуульдаа тайлагнаж байна. Энэхүү үнэлгээний хүрээнд дараах чиглэлээр судалгаа хийж дүгнэн шинжилнэ.

3.6.1.1. сэтгэл ханамжийн үнэлгээ /суралцагчид, төгсөгчдөөс/

3.6.1.2. явцын үнэлгээ /суралцагчийн ахиц дэвшилд үе шаттай хийх үнэлгээ/

3.6.1.3. гүйцэтгэлийн үнэлгээ /ажил олгогч, мэргэжлийн хөндлөнгийн үнэлгээ/

3.6.1.4. үр нөлөөний үнэлгээ /мэргэжлийн салбар дахь нөлөөллийг үнэлэх/

3.6.1.5. хөтөлбөрийн санхүүгийн байдлын үнэлгээ /чанарын үнэлгээ, судалгааг/

3.6.1.6. хөтөлбөрийн чанарын үнэлгээ /чанарын үнэлгээ, судалгааг тодорхой үе шат давтамжтайгаар хийж үр дүнг хөтөлбөрийг хөгжүүлэх, сайжруулах бодлого шийдвэрт ашигладаг байх/

3.6.2. хөтөлбөрийн хэрэгжүүлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш 5 жилийн дотор магадлан итгэмжлэгдэнэ.

3.7. Элсэлт

3.7.1. сургалт эрхлэх зөвшөөрөл авсан магистрын хөтөлбөрөөр, магистрант элсүүлэх бөгөөд магистрын сургалтад элсэгч тухайн мэргэжлээр бакалаврын зэрэгтэй байна. Элсэгч өмнө эзэмшсэнээс өөр чиглэлээр магистрын хөтөлбөрт хамрагдах бол сургалтын агуулгын чанарыг хангахад шаардагдах хичээлийг зөрүүг нөхөн үзнэ. Нөхөж үзсэн хичээлийг магистрын хөтөлбөрийн үндсэн багц цагт тооцохгүй.

3.7.2. жил бүрийн магистрын хөтөлбөрөөр элсэгчийн элсэлтийн шалгалтыг ОТИС-ийн захирлын тушаалаар байгуулсан элсэлтийн комисс зохион байгуулна. Элсэлтийг судалгаа, бусад байгууллагын захиалгад үндэслэн зохион байгуулж болно.

3.7.3. магистрантурт элсэх хүний өмнөх бакалаврын болон магистрын зэргийн боловсролын дипломын голч дүн нь 2.75 /68%/-аас доошгүй байх гэсэн шалгуурыг хангасан байна.

3.7.4. энэ журмын 3.7.3-т заасан болзол, шаардлагыг хангасан магистрын хөтөлбөрт элсэх хүсэлтэй хүн дараах материалыг бүрдүүлж сургуулийн магистрын сургалтын элсэлтийн комисст ирүүлнэ. Үүнд:

3.7.4.1. өргөдөл,

3.7.4.2. анкет,

3.7.4.3. бакалаврын дипломын хуулбар /эх хувийн хамт/,

3.7.4.4. цээж зураг 4 хувь,

3.7.4.5. иргэний үнэмлэхийн хуулбар

3.7.4.6. судалгаа шинжилгээ хийж байсан туршлагатай бол бүтээлийн жагсаалт зэрэг материалыг бүрдүүлэн элсэлтийн комисст ирүүлнэ.

3.7.5. магистрын хөтөлбөрийн элсэгч нь тухайн мэргэжлийн чиглэлээр элсэлтийн шалгалт өгнө.

3.7.6. мэргэжлийн шалгалт бичгийн болон ярилцлагын гэсэн хэлбэрээр 2 үе шаттай байна.

3.7.6.1. бичгийн шалгалтаар тухайн элсэгчийн судалгааны сэдвийн үндэслэл, ач холбогдлыг илэрхийлсэн сэдэмж бичүүлнэ. Элсэлтийн комисс сэдэмжийн дагуу шалгуулагчийн сонгосон судалгааны сэдвийн чиглэлийн профессор багштай сэдвийн тулгамдсан байдлыг хэлэлцэж, эхний шатны шалгаруулалтыг хийнэ.

3.7.6.2. элсэлтийн комисс эхний шалгаруулалтад тэнцсэн шалгуулагчтай ярилцлага хийж, шаардлага хангасан шалгуулагчийг магистрантаар элсүүлэн авна.

3.7.7. ОТИС-ийн захирлын тушаалаар батлагдсан элсэлтийн комисс магистрын хөтөлбөрт элсэгчдийн өргөдөл, элсэлтийн шалгалт, ярилцлагын үр дүн, мэргэжлийн тэнхимийн санал зэргийг үндэслэн тухайн өргөдөл гаргагчийг элсүүлэх тухай шийдвэр гаргана. Уг шийдвэрийг захирлын тушаал гарган баталгаажуулна.

3.7.8. элсэлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд элсэгчид кредит тооцох дэвтэр олгоно.

3.7.9. элсэгч хэрэв өмнө эзэмшсэн бакалаврын мэргэжлээс өөр чиглэлээр магистрын сургалтад хамрагдах бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах зөрүү гарсан хичээлийг нөхөн үзнэ. Нөхөн үзэх хичээлийн багцыг мэргэжлийн тэнхим боловсруулан хөтөлбөрийн дэд хороогоор хэлэлцэн батална.

3.7.10. гадаадын их сургуультай 1:1 хэлбэрийн хамтарсан хөтөлбөр, судлаач оюутан солилцох хөтөлбөр хэрэгжүүлж, ОТИС-ийн магистрын хөтөлбөрөөр төгсөгчдийн мэргэжил дээшлүүлэх сургалт зохион явуулж болох ба хөтөлбөр боловсруулах, сургалтын агуулгыг тодорхойлох, магистрант сонгох, тэдний суралцах нөхцөлийг хангах асуудлыг тусгай журмаар зохицуулна.

3.7.11. Гадаадын иргэнийг сургууль хоорондын хамтын ажиллагааны гэрээгээр магистрын солилцооны хөтөлбөрт суралцуулна.

3.7.12. Магистрант нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургууль хаясан, сургуулийн дотоод журмыг зөрчсөн, суралцах хугацааны төлбөрийг төлөөгүй, төлөвлөгөөнд заасан кредитийг хангаагүй бол ОТИС-ийн захирлын тушаалаар магистрантураас хасна.

3.8. Сургалтын хугацаа

3.8.1. магистрын сургалтын ердийн хугацаа батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу 1,5-2 жил байна.

3.8.2. хичээлийн нэг жил нь 15 долоо хоног бүхий 2 улиралтай байна. Хичээлийн жил болон улирлын график, календарьчилсан төлөвлөгөөг сургалтын нэгдсэн алба гаргаж, суралцагчдад хүргэсэн байна.

3.8.3. магистрант нь элссэнээс хойш 14 хоногийн дотор сургалтын гэрээ байгуулж, тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрөө төлсөн байна.

3.8.4. элсэгч өмнө нь өөр чиглэлээр бакалаврын боловсрол эзэмшсэн бол сургалтын агуулгын залгамж чанарыг хангахад шаардагдах зөрүү гарсан тухайн мэргэжлийн үндсэн хичээлийг нөхөн судална. Нөхөн судалсан хичээлийг магистрын зэрэг олгох үндсэн хичээлд хамруулахгүй.

3.8.5. сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн 20 багц цагийг судалсны дараа гадаад хэлний нэгдсэн шалгалтыг зохион байгуулна. Нэгдсэн шалгалтыг ОТИС-ийн захирлын тушаалаар томилогдсон комисс авах бөгөөд нэгдсэн шалгалтыг А /4,0/, А- /3,6/, В /3,1/, В- /2,7/, /С /2,3/, С- /1,9/, D /1,4/, D- /1,0/, F үнэлгээгээр дүгнэх бөгөөд D буюу түүнээс доош оноо авсан суралцагч гадаад хэлний зохих сургалтад хамрагдан дахин шалгалт өгнө. Энэхүү давтан сургалтын хугацаа болон багтаамж нь сургалтын төлөвлөгөөнд заагдсан үндсэн багц цагт тооцогдохгүй ба нэмэлт кредитийн төлбөрийг магистрант төлнө. Гадаад хэлний сургалтыг магистрантын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд нэмэлт оруулах замаар хугацааг товлон суралцана.

3.8.6. магистрант судалгааны ажлаа эхлүүлэхийн өмнө мэргэжлийн чиглэлээр мэдлэг, бие даасан судалгаа явуулах чадварыг нотлох зорилго бүхий нэгдсэн шалгалт өгнө. Нэгдсэн шалгалтыг тухайн чиглэлийн хөтөлбөрийн хорооны санал болгосны дагуу ОТИС-ийн захирлын тушаалаар баталсан холбогдох мэргэжлийн 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс авна. Мэргэжлийн нэгдсэн шалгалтыг мэргэжлийн хичээл болон мэргэшших хичээлийн агуулгаар авна. Энэхүү шалгалтын дүн, сургуулийн журмаар тогтоосон бусад шаардлагыг хангасан байдлыг үндэслэн нэгжээс судалгааны ажлаа эхлүүлэх албан ёсны зөвшөөрөл олгоно. Нэгдсэн шалгалтад магистрант хангалтгүй /F/ үнэлгээ авсан тохиолдолд дараагийн улиралд дахин 1 удаа өгөхийг зөвшөөрнө.

Дөрөв. Магистрын судалгааны ажил бичих, хамгаалах, хүлээлгэн өгөх

4.1. Судалгааны ажлын сэдэв, төлөвлөгөө

4.1.1. магистрант нь өөрийн сонирхсон сэдвээр судалгаа хийх, удирдагч багшаа сонгох саналаа мэргэжлийн тэнхимд гаргах эрхтэй. Сэдэв нь ОТИС-ийн эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд байна

4.1.2. хөтөлбөрийг хариуцаж буй мэргэжлийн тэнхим сургуулийн эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд, нийгмийн ач холбогдолтой гэж үзсэн мэргэжлийн чиглэлээр сэдвийн ерөнхий томъёолол, удирдагч багшийг магистрантуудад санал болгоно. Магистрант элссэнээсээ хойш 3 сарын дотор судалгааны ажлынхаа сэдвийг томъёолж бүтцийн сургуульд хүргүүлнэ.

4.1.3. бүтцийн сургууль нь магистрант нэг бүрээр судалгааны сэдвийг томъёолж, тухайн сэдвээр мэргэшсэн эрдэм шинжилгээний ажлын удирдагчийг томилох саналыг боловсруулж сургалтын нэгдсэн албанд хүргүүлнэ.

4.1.4. сургалтын нэгдсэн албанаас удирдагч багшийг томилох саналыг боловсруулж ОТИС-ын захирлын тушаалаар баталгаажуулна.

4.1.5. магистрант судалгааны сэдэв, удирдагч багшийн саналаа хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгжид эхний улирлын сүүлийн долоо хоногт гаргана. Магистрантаас судалгааны ажлын сэдэв, удирдагч багш томилох саналыг хүлээн хүлээн авснаас хойш 21 хоногийн дотор сэдэв, удирдагчийг томилно.

4.1.6. магистрын судалгааны ажлын сэдэв, удирдагч албан ёсоор батлагдсаны дараа магистрант бүр удирдагчтайгаа хамтран судалгааны ажлын ганцаарчилсан төлөвлөгөө гаргаж төлөвлөгөөний дагуу судалгааны ажлыг хийнэ.

4.1.7. магистрант судалгааны ажлын явц, удирдагч багшийн магистранттай хамтран ажилласан байдлыг үнэлэх товч тайланг хичээлийн жилийн эцэст тусгай маягтаар хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн эрхлэгчид ирүүлнэ. Тэнхимийн эрхлэгч тухайн маягтаар ирсэн мэдээллийг нэгтгэн дүгнэж, тайланг ЗХШҮА-д хүргүүлнэ.

4.1.8. удирдагч багш Судалгааны ажлын явц, магистранттай хамтран ажиллах байдлыг үнэлэх товч тайланг хичээлийн жилийн эцэст тусгай маягтаар хөтөлбөр хэрэгжүүлэгч тэнхимийн эрхлэгчид ирүүлнэ. Тэнхимийн эрхлэгч тухайн маягтаар ирсэн мэдээллийг нэгтгэн дүгнэж, тайланг ЗХШҮА-д хүргүүлнэ.

4.1.9. ЗХШҮА нь магистрант болон удирдагч багшийн хамтын ажиллагааны үр дүнг хичээлийн жилийн эцэст магистрант болон удирдагч багшийн тайланд үндэслэн нэгтгэж сургалт эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захиралд тайлагнана.

4.2. Магистрын судалгааны ажил хамгаалах

4.2.1. магистрын судалгааны ажил нь хэлбэр, агуулга, бүтэц, бүрдэл, хэмжээний хувьд тус сургуулийн “ОТИС-ийн сургалтын хэрэглэгдэхүүн, судалгааны ажилд тавиглах ерөнхий шаардлага”-ын дагуу бичиж хэвлүүлнэ.

4.2.2. магистрын ажил нь тухайн шинжлэх ухааны тодорхой асуудлыг гүнзгийрүүлсэн судалгаа, туршилт, боловсруулалт, дүн шинжилгээ, онол арга зүйн зохих түвшинд гүйцэтгэж, тухайн асуудлын шинжлэх ухааны үндэслэл, онол практикийн дүгнэлт зэрэг үр дүнд хүрсэн эрдэм шинжилгээний нэгэн сэдэвт бүтээл байх шаардлагыг хангасан байна.

4.2.3. магистрын ажлыг магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална. Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг бүтцийн сургуулийн саналыг үндэслэн ОТИС-ын захирлын тушаалаар байгуулна. Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийг БШУ-ны сайдын баталсан “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-ийн дагуу байгуулах ба тус зөвлөл нь энэхүү журмын хүрээнд ажиллана.

4.2.4. магистрант сургалтын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, гадаад хэлний шалгалтаа өгсөн, сургалтын төлбөрөө төлсөн, магистрын ажлаа тэнхим/эрдэм шинжилгээний их семинарт урьдчилан хэлэлцүүлсэн тухай бүтцийн сургуулийн дүгнэлтийг үндэслэн, магистрын зэрэг хамгаалуулахыг зөвшөөрсөн тухай ОТИС-ийн захирлын тушаал гаргаж, магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд уламжилна.

4.2.5. сургалтын кредитээ биелүүлсэн боловч дипломын ажлаа хугацаандаа хийж дуусаагүй хүндэтгэн үзэх шалтгаантай магистрантын хамгаалах хугацааг 1-2 жилээр сунгана. Энэ тохиолдолд шаардлагатай гэж үзвэл судалгааны ажилтай холбогдох нэмэлт зардал төлүүлж болно.

4.3. Магистрын судалгааны ажлын урьдчилсан хамгаалалт

4.3.1. магистрын ажлын урьдчилсан хамгаалалтыг магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нэгж зохион байгуулна.

4.3.2. урьдчилсан хамгаалалтаар магистрын ажлыг жинхэнэ хамгаалалтад оруулах тухай зөвлөмж шийдвэрийг гаргана. Эрдэм шинжилгээний их семинарт судалгааны ажлаа хэлэлцүүлээгүй бол урьдчилсан хамгаалалтад оруулахыг зөвшөөрөхгүй.

4.3.3. урьдчилсан хамгаалалтаар тухайн магистрын ажлын онол арга зүй, агуулгын багтаамж, үр дүн, магистрын ажлын бичлэгийн шаардлагыг хангасан эсэх, өмнөх хэлэлцүүлгээр өгөгдсөн санал шүүмж туссан эсэх, урьдчилсан хамгаалалтын үеэр тухайн магистрын ажлын ихэнх хувь нэмэн засварлагдах шаардлагатай гэж үзэх, судалгааны үр дүн, сэдвийн хувьд алдаатай гэж үзвэл тухайн ажлыг жинхэнэ хамгаалалтын шаардлага хангаагүй гэж үзэж, цаашид жинхэнэ хамгаалалтад оруулахаас татгалзана.

4.3.4. дээрх заалтын шаардлагыг биелүүлсэн бөгөөд тухайн магистрантын ажил утга найруулга зэргээс бусад үндсэн үр дүнг хамгаалах зөвлөлийн гишүүд зөвшөөрсөн бол уг ажлыг жинхэнэ хэлэлцүүлэгт оруулахаар шийдвэрлэнэ.

4.4. Магистрын судалгааны ажлын жинхэнэ хамгаалалт

4.4.1. магистрын ажлын жинхэнэ хамгаалалтыг магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаална.

4.4.2. магистрын ажил хамгаалуулах зөвлөлийн хуралдаанд орсон гишүүдийн 75-аас доошгүй хувийн эерэг санал авсан тохиолдолд тухайн ажлыг шаардлага хангасан гэж үзнэ.

4.4.3. магистрын ажлын хамгаалуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга хуралдааны протокол шийдвэрийг сургалтын нэгдсэн албанд хүргэнэ.

4.4.4. магистрын ажлын хамгаалуулах зөвлөлийн жинхэнэ хамгаалалтын хуралдаанаас “ОТИС-ийн сургалтын хэрэглэгдэхүүн, судалгааны ажилд тавих ерөнхий шаардлага”-ын 2.3-ыг хангаагүй бол магистрын ажлыг хэлэлцэхгүйгээр буцаах эрхтэй.

4.4.5. магистрын ажлаа хамгаалж чадаагүй магистрант 2 жилийн дотор дахин нэг удаа хамгаалуулах зөвлөлд хэлэлцүүлэх эрхтэй. Энэ тохиолдолд шаардлагатай гэж үзвэл судалгааны ажилтай холбогдох нэмэлт зардал төлүүлж болно. Хүндэтгэх бус шалтгаанаар хугацаа сунгахгүй

4.5. Магистрын судалгааны ажлыг хүлээлгэн өгөх

4.5.1. магистрын судалгааны ажлын оюуны өмчийн эрх нь түүнийг бичсэн суралцагч болон ОТИС-д хамаарагдана.

4.5.2. амжилттай хамгаалсан магистрын судалгааны ажлыг тогтоосон журмын дагуу бүрэн эхээрээ сургуулийн архивд хадгалах буюу 1-2 хувийг сургуулийн номын сан, Эрдэм шинжилгээний төвд шилжүүлж нийтийн хүртээл болгоно. Судалгааны эх ажлыг бусдад олноор нь болон хоногоор өгч явуулахыг хориглоно

4.5.3. эрдэм шинжилгээ, судалгааны төв магистрын судалгааны ажлаар мэдээллийн электрон сан үүсгэж, жил бүр баяжуулан хадгална. Энэхүү санг бүрдүүлэх ажлыг Эрдэм шинжилгээ, судалгааны төвийн эрхлэгч хариуцан гүйцэтгэнэ.

4.6. Магистрын зэрэг олгох

4.6.1. Магистрын судалгааны ажлыг амжилттай хамгаалсныг баталсан магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн тогтоолыг үндэслэн ОТИС-ийн захирлын тушаалаар магистрын зэрэг олгох шийдвэр гаргана. Энэхүү шийдвэрийг үндэслэн сургалтын нэгдсэн алба магистрын зэрэг олгосон дипломыг бичиж, гардуулах ажлыг зохион байгуулна

Тав. Сургалтын зардал

1.1. Магистрантурт суралцагчдын төлбөрийн хэмжээг сургуулийн удирдах зөвлөлийн хурлаар жил бүр шинэчлэн тогтоож мөрдөнө.

1.2. Суралцаж буй улирлын сургалтын зардлыг хичээл эхэлснээс хойш 14 хоногт багтаан сургуулийн дансанд тушаасан байна. Сургалтын зардлаа хүндэтгэх шалтгаангүйгээр хугацаанд нь төлөөгүй магистрантыг цаашид үргэлжлүүлэн суралцуулахгүй.

1.3. Суралцагч төлбөрийг улирал, жилээр төлж болох ба энэ тухай ОТИС-ийн захиралтай байгуулах гэрээнд тусгана.

1.4. Суралцагч сурлага, сахилгаар хасагдах болон хүсэлтээрээ чөлөөлөгдөх үед улс, захиалагч байгууллагаас төлсөн зардлыг буцааж төлөх тохиолдолд түүнийг суралцагч өөрөө хариуцна

1.5. Суралцагч нь суралцах хугацаандаа сургуулийн дотоод журмын хүрээнд ОТИС-ийн номын сан, компьютерын болон эрдэм шинжилгээ, судалгааны төвд буй мэдээллийн сан болон холбогдох программуудыг ашиглах эрхтэй.

1.6. Магистрантаар хичээлд туслуулах, магистрантын төлбөрийг хөнгөлөх, тэтгэлэгт хамруулах, профессорын гүйцэтгэж байгаа эрдэм шинжилгээний сэдэвт ажил, төсөлд магистрантыг ажиллуулж судалгааг санхүүжүүлэх чиглэлээр удирдагч багш, профессорын баг/тэнхим, сургууль санаачилгатай ажиллах үүрэг хүлээнэ.

Зургаа: Номын сан, мэдээллийн бааз

6.1. ОТИС-ын номын сан болон Эрдэм, шинжилгээ, судалгааны төвийн бичил номын сан нь магистрын сургалтын чиглэл бүрээр мэргэжлийн сэтгүүл захиалдаг, интернэтэд холбогдсон, мэргэжлийн сэтгүүл, ном зүйн лавлагаа, нэг сэдэвт зохиол, эрдэм шинжилгээний цувралын сангаар хангах үүрэг хүлээнэ.

6.2. Сургалтын нэгдсэн алба нь магистрантыг сургуулийн орчинд интернэт ашиглах боломжоор хангана.

6.3. ОТИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны төвөөс эрхлэн гаргадаг “Отгонтэнгэр” эрдэм шинжилгээний бичиг нь ОТИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүл байна.

6.4. “Отгонтэнгэр” эрдэм шинжилгээний бичгийн редакцын зөвлөлөөс судалгааны ажлын шаардлага хангасан гэж үзсэн тохиолдолд магистрант нь өөрийн судалгааны ажлын чиглэлээр эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны ажлын тойм зэргийг ОТИС-ийн эрдэм шинжилгээний сэтгүүлд хэвлүүлж, судалгааны сэдвийн хүрээнд эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж болно.